



**ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/310

Улаанбаатар хот

「 2019 оныг “Бүтээмжийн жил” болгон зарлаж,
зорилт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 8.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газраас 2019 онд ажилтнуудыг чадавхжуулан дэмжиж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээний стандарт, чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 2019 оныг “Бүтээмжийн жил” болгон зарласугай.
2. “Бүтээмжийн жил”-ийн хүрээнд дэвшүүлсэн зорилтыг 1 дүгээр хавсралтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын явц, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг хэлтэс, салбарын дарга нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Л.Намжилмаа/-д даалгасугай.

ДАРГА




Ж.БАТСАЙХАН

2150304298

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын
даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
...1310 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

2019 ОНЫГ "БҮТЭЭМЖИЙН ЖИЛ" БОЛГОН ЗАРЛАЖ,
ЗОРИЛТ БАТЛАХ ТУХАЙ



Д/д	Зорилт
1	Ажилтнуудыг чадавхжуулан дэмжиж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх
2	Үйлчилгээ, үйл ажиллагааны стандарт, чанар хүртээмжийг сайжруулж хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
3	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын
даргын 2018 оны 12. дугаар сарын 26-ны өдрийн
...А.310 дугаар тушаалын 2. дугаар хавсралт

**“ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
“БҮТЭЭМЖИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ЖАГСААЛТ**

Д/д	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах хэлтэс	Хамтран ажиллах хэлтэс, салбар
1	Удирдлага зохион байгуулалтын сар	1 дүгээр сар	Захиргаа, удирдлагын хэлтэс	Бусад хэлтэс, салбар
2	Байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлан таниулах сар	2 дугаар сар	Хэрэглэгчийн үйлчилгээ, гэрээ, мониторингийн хэлтэс	Бусад хэлтэс, салбар
3	Ажилтнуудыг чадавхжуулах сар	3 дугаар сар	Захиргаа, удирдлагын хэлтэс	Бусад хэлтэс, салбар
4	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн сар	4 дүгээр сар	Хөрөнгө оруулалт, хангамжийн хэлтэс	Инженерийн бодлого, хяналтын хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс
5	Хөдөлгөөн эрүүл мэндийн сар	5 дугаар сар	Биеийн тамир спорт хамтлаг	Бусад хэлтэс, салбар
6	Хууль тогтоомж журмын хэрэгжилт хангуулах сар	6 дугаар сар	Захиргаа, удирдлагын хэлтэс, Хэрэглэгчийн үйлчилгээ, гэрээ, мониторингийн хэлтэс	Бусад хэлтэс, салбар
7	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сар	7 дугаар сар	Инженерийн бодлого, хяналтын хэлтэс	Бусад хэлтэс, салбар
8	Их болон урсгал засварын ажлыг эрчимжүүлэх сар	8 дугаар сар	Инженерийн бодлого, хяналтын хэлтэс	Бусад хэлтэс, салбар
9	Орлого, нэмэгдүүлж хуримтлагдсан өр авлагыг бууруулах сар	9 дүгээр сар	Санхүү, эдийн засгийн хэлтэс	Бусад хэлтэс, салбар
10	Ус, дулаан, цахилгааны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх сар	10 дугаар сар	Инженерийн бодлого, хяналтын хэлтэс	Бусад хэлтэс, салбар
11	Үйлчилгээ, үйл ажиллагааны стандарт, чанар хүртээмжийг сайжруулах сар	11 дүгээр сар	Хэрэглэгчийн үйлчилгээ, гэрээ, мониторингийн хэлтэс	Бусад хэлтэс, салбар
12	“Бүтээмжийн жил”-ийн хүрээнд хийгдсэн ажлын биелэлтийг дүгнэж, 2020 оны зорилтыг тодорхойлох сар	12 дугаар сар	Захиргаа, удирдлагын хэлтэс	Бусад хэлтэс, салбар